Тус төвийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2015 онд боловсруулагдсан Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй, шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж үзсэн тул түүнийг сайжруулах зөвлөмж өгсөн.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Хүүхдийн төв сувиллын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар 2020 оны шилэн дансанд дотоод аудит хийгээгүй байна.

Хүүхдийн төв сувиллын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт сул байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,238,457.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,384.6 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас дахин тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд 2020 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,082,045.3 мянган төгрөгийн 1 хувь буюу 30,820.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүүхдийн төв сувиллын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,362.5 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж төлсөн зардал, бараа материалын данс өссөн, үндсэн хөрөнгийн данс буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	17,189.2	0.00	(17,189.2)
Урьдчилж төлсөн зардал	0.00	66,523.8	66,523.8
Бараа материал	139,691.9	270,843.5	131,151.6
Үндсэн хөрөнгө	4,146,426.0	3,973,302.3	(173,123.7)
Нийт хөрөнгө	4,303,307.1	4,310,669.6	7,362.5
Өглөг	2,667.9	0.00	(2,667.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,300,639.2	4,310,669.6	10,030.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,303,307.1	4,310,669.6	7,362.5

Тайлант онд өмнөх оны авлагын үлдэгдэл 17,189.2 мянган төгрөг, өр төлбарийн үлдэгдэл 2,667.9 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан байна.

Урьдчилж төлсөн зардлын дансны үлдэгдэл 66,523.8 мянган төгрөгөөр өссөн нь цар тахлын улмаас худалдан авах ажиллагаа хойшилж, гүйцэтгэл нь гараагүй ажлын төлбөр ба тооцоо нийлж баталгаажуулсан байна

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 131,151.6 мянган төгрөгөөр өссөн нь 1.9 дахин өссөн нь ЭМЯ болон ХӨСҮТ-өөс Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хандив, тусламжаар ариутгалын бэлдмэл, хамгаалах хувцас, хэрэгсэл, эм бэлдмэл ирүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 173,123.7 мянган төгрөгөөр буурсан нь 34,375.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан болон элэгдлийн зардал 214,076.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хүүхдийн төв сувиллын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 6.2 хувь буюу 181,546.2 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оноос урсгал санхүүжилт 266,585.5 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 19,274.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээр голлон шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 10.3 хувь буюу 287,789.3 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2019 оны 395 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 23 дугаар албан даалгавраар шөнийн нэмэгдэл олгох, эмч, эмнэлгийн ажилтны төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдэл, үр дүнгийн мөнгөн урамшууллын хувь хэмжээ нэмэгдсэнээс 178,625.9 мянган төгрөг, НДШ 24,100.7 мянган төгрөг, эм эмийн хэрэгсэл, бусад зардал 85,062.7 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан байна. Мөн үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол, төсөвт буцаан төвлөрүүлсэн дүн нөлөөлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжих 3,034,670.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 161,728.4 мянган төгрөгөөр хасагдаж 2,872,942.3 мянган төгрөгөөр батлагдсан байна. Үүнээс цалин хөлс, эд хогшил худалдан авах, урсгал засвар гэх мэт зардлууд хасагдан ирсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэх 2,872,942.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,872,942.3 мянган санхүүжилт авч нийт 22,183.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,605,084.7 мянган төгрөгийг зарцуулж 290,041.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Дээрх байдлаас харахад анх төсвийн төслийн нийт зардлыг 161,728.4 мянган төгрөгөөр бууруулж батлаад оны эцэст 290,041.7 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн нь төсвийг үндэслэлгүй, бодитой бус төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,605,084.7 мянган төгрөг буюу 90.6 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардалд 203,353.2 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна. Орон тоо нь дутуу ажлын байран дээр сонгон шалгаруулалт зарласан боловч шаардлага хангаагүй тул дотооддоо зохицуулалт хийн ажилласан ба ковид-19 цар тахалтай холбоотойгоор зарим тасаг нэгж хаагдсанаар илүү цагийн хөлс тодорхой хэмжээнд багассан байна.

Мөн тогтмол зардал гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, түлш халаалт, дотоод албан томилолт, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал дутуу зарцуулагдсан байна.

Нийт хэрэгжүүлэх эрүүл мэндийн хөтөлбөрийн зардлын дутуу зарцуулалт нь үндсэн үйл ажиллагаа 290,040.9 мянган, төрийн албан хаагчдад олгох мөнгөн урамшуулал 33,464.1 мянган төгрөгийн арга хэмжээнүүдийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний үзүүлэлт /мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эрүүл мэнд	2,872,942.3	2,582,901.43	290,040.87	89.9
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны	2,703,276.30	2,446,699.53	290,040.87	90.5
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	155,704.00	122,239.9	33,464.10	78.51
1.3	80219	Харуул хамгаалалтын зардал	12,000.00	12,000.0	0.00	100
1.4	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх	1,962.00	1,962.0	0.00	100

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу шалгагдагч байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2020 оны байдлаар нэмэлт санхүүжилтээр туслах үйл ажиллагааны орлого 74,160.0 мянган төгрөг, урьд оны татаас санхүүжилтийн авлага 1,628.0 мянган төгрөгийг ЭМЯ болон Сангийн ямаар зарцуулах эрхийн зөвшөөрөл авч үйл ажиллагаандаа зарцуулсан. Давсан орлогыг сангийн сайдын 74 дүгээр тогтоолын дагуу ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаа, цалин хөлс болон байгууллагад шаардлагатай бусад зардалд зарцуулсан байна.

Үүнээс цалин хөлс 35,988.2 мянга, ажил олгогчоос төлөх НДШ-д 4,440.9 мянга, хангамж, бараа материалын зардалд 12,080.6 мянга, норматив зардалд 6,858.0 мянга, багаж техник хэрэгсэл худалдан зардалд 12,519.0 мянга, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулалд 3,900.0 мянган төгрөг нийт 75,787.2 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 0.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шалгагдагч байгууллага шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус эмнэлэг нь Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны мэдээллийг сарын бүрийн 8-ны дотор байршуулж хэвшсэн ба тайлант онд нийт 107 мэдээллээс 91-ийг хугацаандаа оруулж, ковидтой холбоотой хандив тусламжийн мэдээлэл 7 сард нэмэгдсэнийг нөхөж 14-ийг хугацаа хоцроосон ба 2 мэдээллийг оруулаагүй байна.

Бусад мэдээ мэдээлэл хуулийн хугацаанд байршуулан ажиллаж сар бүр, тухай бүр нь оруулах мэдээлэл, хагас жил бүтэн жилээр төсвийн хэтэрсэн хэмнэсэн зардал, 5 саяас дээш орлого зарлагын мэдээлэл, худалдан авалтын тухай мэдээллийг бүтэн жилээр байршуулж улирал бүрийн 10-ны дотор ЭМЯ-нд тайлагнан ажилласан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх он		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1		1		-	-	100.0
Зөвлөмж	1		1		-	-	100.0
Нийт дүн	2		2		-	-	100.0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 96,135.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 66,717.8 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 29,417.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- ✚ Гэрээний дагуу камержуулалд, засвар үйлчилгээний ажлыг хийгээгүй урьдчилж орсон орлогоор бүртгэсэн 66,717.8 мянган төгрөгийн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлаар бүртгэж зөрүүтэй тайлагнасан бүртгэлийн алдааг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын баталсан маягт аргачлалын дагуу хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайлан, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй. Энэ нь

- ✚ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл 54.5-д Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна; 54.5.1-д тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/; 54.5.3-д тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл; 54.5.4-д хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/; 54.5.5-д нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга;
- ✚ Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар батлах журмын 2 дугаар хавсралт;
- ✚ Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 1 дүгээр хавсралт 1.4-д Төсвийн эрх захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлант оны төсвийн хэтрэлт, хэмнэлт түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаарх дэлгэрэнгүй тайлбар танилцуулга хавсаргана, 2.3-д Төсвийн байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг ТГТ-1 а маягтын дагуу гарган төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 29,417.4 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх, цалин хөлсний тушаал шийдвэр гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн байдлын тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл тооллогын бүртгэлээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх"- заалтыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв тайлагнаагүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

- Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг зөв хийж эд хариуцагчийн тайланд хяналт тавьж үлдэгдлийг баталгаажуулах, түүнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд 1,768.0 мянган төгрөгийн бараа материалын дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.21-д "Бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед Дт.

Хангамжийн материал, Кт.Мөнгөн хөрөнгө/Дансны өглөг” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.2. Эрсдэл:

Бараа материалыг данс бүртгэлд тусгалгүй шууд зардлаар тайлагнасан байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

- Бараа материалыг данс бүртгэлд тусгаж, зарцуулж байх;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3. НБББББ-тэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тус төвийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2015 онд боловсруулагдсан ба холбогдох стандарт, хууль тогтоомжийг өөрчлөлтийг тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” дагуу НБББББ-ийг шинэчлэн боловсруулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Дүрэм журам хэрэгжихгүй, хөрөнгө дутагдах, шамшигдах,

3.3. Өгсөн зөвлөмж:

Хууль тогтоомжид заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох стандарт, эрх зүйн актуудыг өөрчлөлтийг оруулан боловсруулж, мөрдөж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Бараа материал дансанд 13,220.0 мянган төгрөгийг ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгосон талоноор зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

4.2. Эрсдэл:

Төсвийн зарцуулалтад тавих хяналт сулрах, бүртгэл буруу илэрхийлэгдэх

4.3. Өгсөн зөвлөмж:

Шатахуун зарцуулалтын данс бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, стандартын дагуу зөв бүртгэж тайлагнаж байх.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

5. И-баримтгүй худалдан авалттай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тайлант онд 46 ААНБ-аас худалдан авалт хийсэн гүйлгээг татварын цахим бүртгэлийн систем дэх төлбөрийн баримттай тулган шалгахад 18 ААНБ-ын 14,429.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

5.2. Эрсдэл:

Нягтлан бодогч анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгаж тайлагнасан байх

5.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодогч Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэж заасны хэрэгжүүлж төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хүүхдийн төв сувиллын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2020/56/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хүүхдийн төв сувилал		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн байдлын тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл тооллогын бүртгэлээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх"- заалтыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.	1,205.0	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Оюунцэцэг Ж.Оюунзаяа
2	Бараа материал дансанд 13,220.0 мянган төгрөгийг ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгосон талоноор зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.	13,220.0	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Оюунцэцэг Ж.Оюунзаяа
3	Тайлант онд 1,768.0 мянган төгрөгийн бараа материалын дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.21-д "Бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед Дт. Хангамжийн материал, Кт.Мөнгөн хөрөнгө/Дансны өглөг" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.	1,768.0	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Оюунцэцэг Ж.Оюунзаяа

Хүүхдийн төв сувиллын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Тайлант онд 46 ААНБ-аас худалдан авалт хийсэн гүйлгээг татварын цахим бүртгэлийн систем дэх төлбөрийн баримттай тулган шалгахад 18 ААНБ-ын 14,429.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.	14,429.4	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Оюунцэцэг Ж.Оюунзаяа
5	Тус төвийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2015 онд боловсруулагдсан ба холбогдох стандарт, хууль тогтоомжийг өөрчлөлтийг тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2."Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" дагуу НБББББ-ийг шинэчлэн боловсруулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.		Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Оюунцэцэг Ж.Оюунзаяа
6	Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын баталсан маягт аргачлалын дагуу хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайлан, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй.		Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Оюунцэцэг Ж.Оюунзаяа
ДҮН		30,622.4			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 135/А 0170064

Улаанбаатар хот

САТ-0021/56/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүүхдийн төв сувиллын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын баталсан маягт аргачлалын дагуу хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайлан, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй.

- Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл 54.5-д Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна; 54.5.1-д тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/; 54.5.3-д тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл; 54.5.4-д хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/; 54.5.5-д нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга;
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар батлах журмын 2 дугаар хавсралт;
- Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 1 дүгээр хавсралт 1.4-д Төсвийн эрх захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлант оны төсвийн хэтрэлт, хэмнэлт түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаарх дэлгэрэнгүй тайлбар танилцуулга хавсаргана, 2.3-д Төсвийн байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг ТГТ-1 а маягтын дагуу гарган төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хууль, Сангийн сайдын тушаалуудаар батлагдсан журмуудын дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангуудад тодруулга, танилцуулга тайлбар бэлтгэж жилийн санхүүгийн тайлантай хамт хүргүүлж байх. Биелэлтийг 2020 оны 07 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхдийн төв сувиллын захирал Д.Оюунцэцэг, нягтлан бодогч Ж.Оюунзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР




П.АМАРСАНАА

МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ:



Д.ТҮМЭНЖАРГАЛ



ТЭМДЭГЛЭЛ

Lined area for the conclusion with horizontal dotted lines.